



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.3, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон нийт 1,093,677,113.00 (нэг тэрбум ерэн түрүүнээс дээш) гурван сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун арван гурван) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан Шинэ эхлэл сургуулийн барилгын өргөтгөлийг тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга Л.Цэдэвсүрэн, Шинэ эхлэл сургуулийн захирлын үүргийг түр хавсрлан гүйцэтгэгч Н.Оюунгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хавсралтад заасан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтаар хүлээн авах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн  
330 дугаар толгoolынхавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ТӨРИЙН ӨМЧИД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Нийт өртөг /төгрөгөөр/ дугаар	Ашиглалтад орсон он, сар, өдөр, актын дугаар	Бүртгэж авах хуулийн этгээд
1	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Шинэ эхлэл/	1,093,677,113.00	2019.10.23 №2019/494	Шинэ эхлэл сургууль
	<b>Нийт дүн</b>	<b>1,093,677,113.00</b>		(нэг тэрбум ерэн гурван сая зураган зуун далан долоон мянга нэг зуун арван гурав)

---000---